



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус
гишүүдийг томилох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх түр хорооны дүгнэлт, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 05/6378 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус гишүүнээр Б.Буянхишиг, Л.Ганбаатар, Д.Санчир нарыг 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн томилсугай.

2.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг судалж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг хараат бус гишүүдэд, мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулан авахыг компанийн эрх бүхий албан тушаалтнуудад тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132002309